



ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГА Г.ӨЛЗИЙБҮРЭН
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.07 № 2/08 УАГ-САГ/2014/10/СТА-ТШЗ

Асуудал шийдвэрлэх тухай

Газрын тосны газрын 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Уул уурхайн яамны холбогдох ажилтнуудын гадаад томилолт, шатахуун, хүлээн авалтын зардалд нийт 46.7 сая төгрөгийг өөрийн орлогоосоо санхүүжүүлсэн зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д: "Хуульд өөрөөр заагаагүй бол төр өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д: "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д: "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т: "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д ".....алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна.

1. Уул уурхайн яамтай холбоотой дээрхи зардлуудыг өөрийн орлогоос санхүүжүүлдэг явдлыг таслан зогсоох
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2014 оны 10 дугаар сарын 1-ний дотор ирүүлэхийг СЭЗХОХ-ийн дарга С.Нямдорж, Ерөнхий санхүүч Б.Оюун нарт даалгаж байна.

АУДИТОР



П.ЧАНЦАЛДУЛАМ

070316